



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Г Сургалт явуулах гэрээний загвар болон өргөдлийн маягтууд батлах тухай

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1.8, Засгийн газрын 2016 оны 295 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтын 1.3, 2.1.2 дох заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх, мэргэшүүлэх сургалт явуулах байгууллагатай байгуулах гэрээний загварыг нэгдүгээр, Сургалт явуулахыг сонирхогч хуулийн этгээдээс Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд гаргах өргөдлийн маягтыг хоёрдугаар, Сургалтад хамрагдах суралцагчаас сургалтын байгууллагад гаргах өргөдлийн маягтыг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. “Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журам”-д заасан шаардлага хангасан сургалтын байгууллагатай батлагдсан гэрээний загварын дагуу сургалт явуулах гэрээ байгуулж ажиллахыг Эрчим хүч хэмнэлтийн хэлтэс /Ц.Атаржаргал/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Х.Эрдэнэчuluун/-нд даалгасугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

С.ОТГОНБАЯР

Д.БАССАЙХАН

Э.ТҮВШИНЧУУЛУУН

Эрчим хүчний зохицуулах хорооны
2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн
161 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

УХА0315 9128803

БАТЛАВ.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ДАРГА

С.ОТГОНБАЯР

БАТЛАВ.

СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

ТӨЛӨӨЛЖ

СУРГАЛТ ЯВУУЛАХ ГЭРЭЭ

2016 он ... сар ...өдөр

№..

Улаанбаатар хот

Иргэний хуулийн 189, 193, 195, 196, 476, 478 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 295 дугаар тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох” журмыг удирдлага болгон нэг талаас “**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**” (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас “**СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН НЭР**” (цаашид “Сургалтын байгууллага” гэх) хуулийн этгээдийн хооронд дээрх журмыг хэрэгжүүлэх хүрээнд талуудын хамтын ажиллагааны чиглэл, цар хүрээ, зохион байгуулах арга хэмжээ болон эрх, үүрэг, хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. **СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА** нь эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэх, мэргэшүүлэх доорх сургалтуудыг өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу явуулна.

Үүнд: /байгууллагын чадамжид тулгуурлан сонголт хийх/

1.1.1. Эрчим хүчний аудитор – үйлдвэрлэл болон үйлчилгээ /цахилгаан, дулаан, хий-/ний чиглэлээр бэлтгэх, мэргэшүүлэх сургалт;

1.1.2. Эрчим хүчний аудитор – барилга, байгууламжийн чиглэлээр бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг;

1.1.3. Эрчим хүч хэмнэлтийн менежерийн чиглэлээр бэлтгэх, мэргэшүүлэх сургалт.

1.2. Захиалагчийн баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт явуулах бөгөөд сургалтын хөтөлбөрийг хэмнэлтийн арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлтэй уялдуулж баяжуулан өөрчлөх асуудлаар сургалтын байгууллага захиалагчид албан хүсэлт, санал гаргана.

1.3. Сургалт явуулах хугацаа, эхлэх, дуусах товыг талууд харилцан тохиролцож, сургалтын нарийвчилсан төлөвлөгөөнд тусгах ба төлөвлөгөөг гэрээнд хавсаргана.

Хоёр. Гэрээний хугацаа ба сунгалт

- 2.1. Сургалт явуулах гэрээний хугацаа 1 жил байх бөгөөд 2 жилээр сунгаж болно.
- 2.2. Гэрээ сунгах албан хүсэлтийг сургалтын байгууллага гэрээний хугацаа дуусахаас 1 сарын өмнө захиалагчид ирүүлнэ.
- 2.3. Захиалагчийн зүгээс сургалтын чанарт өгсөн үнэлгээг харгалзан гэрээг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.4. Доорх заалтуудын үнэлгээ 70% ба түүнээс доош үнэлэгдсэн бол гэрээг сунгахгүй. Үүнд:
 - 2.4.1. Сургалтад хамрагдагчдаас авсан санал асуулга, сэтгэл ханамжийн судалгааны үр дүн;
 - 2.4.2. Сургалтын үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар захиалагч, ажил олгогч, эсхүл суралцагчаас гаргасан гомдол, шаардлагын биелэлт.

Гурав. Сургалтын төлбөр

- 3.1. Сургалтын төлбөрийг ижил төстэй сургалтын төлбөрийн хэмжээ, багшийн нэгж цагийн үнэлгээнд тулгуурлан захиалагчийн саналыг тусган, сургалтын байгууллага тогтоох бөгөөд төлбөрийн хэмжээг тогтоосон үндэслэл, зардлын ерөнхий мэдээллийг гэрээнд хавсаргана.
- 3.2. Сургалтын төлбөрт доорх зүйлийг багтаана.
 - 3.2.1. Сургагч багшийн цагийн хөлс, дагалдах татвар, хураамж;
 - 3.2.2. Сургалтын байгууллагаас гарах зардал;
 - 3.2.3. Шалгалтын үйл ажиллагаатай холбоотой зардал;
 - 3.2.4. Төгсөгчийн гэрчилгээ, дардас, үнэмлэхийн зардал;
 - 3.2.5. Сургалтын баазыг хөгжүүлэх зардал;
 - 3.2.6. Болзошгүй бусад зардал.
- 3.3. Төгсөгчийн гэрчилгээ, дардас, үнэмлэх зэргийг хэвлүүлэхтэй холбоотой ажлыг захиалагч хариуцаж хийх бөгөөд сургалтын байгууллагаас үүнтэй холбоотой зардлыг нэхэмжлэхийн дагуу шийдвэрлэнэ.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1. Сургалтад хамрагдагчдаас санал асуулга авах замаар сургалтын байгууллагын үйл ажиллагаа, чанарт хяналт тавина.
- 4.2. Сургалтын үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар санал гаргаж, шаардлага тавина.
- 4.3. Шалгалтын дүнг үндэслэн эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийн эрх олгох эсэх шийдвэрийг гаргана.
- 4.4. Сургалтын байгууллагын талаарх мэдээллийг олон нийтэд өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.
- 4.5. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс баталсан сургалтын хөтөлбөр, материалыг гэрээний хугацаанд сургалтын байгууллагад ашиглуулна.
- 4.6. Сургалтын байгууллага сургалтын тайланг суралцагчийн өргөдөлд хавсаргасан баримт бичиг, эрх олгох шалгалтад хамруулах хүсэлтийн хамт ирүүлсэнээс хойш ажлын 7 хоногт багтаан сургалтын байгууллагатай хамтран шалгалт авах ажлыг зохион байгуулна.

Тав. Сургалтын байгууллагын эрх, үүрэг

- 5.1. Сургалтад хамрагдах нөхцөл, шаардлагыг хангасан суралцах хүсэлтэй

болон үүрэг хүлээсэн хэрэглэгчээс эрчим хүч хэмнэлтийн менежерээр томилсон мэргэжилтнийг сургалтад хамруулахад захиалагчтай зөвшилцөнө.

5.2. Нэг удаагийн сургалтад 25-аас ихгүй суралцагч хамруулна.

5.3. Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу чанартай явуулах бөгөөд сургалтын материал, гарын авлага, сургалтад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр суралцагчдыг хангана.

5.4. Сургалтын явцад суралцагчдын ирц, идэвх зэрэг оролцоонд сургагч багш нар хяналт тавина.

5.5. Дадлага ажил, бичил төслийг хэрэгжүүлэх объектыг сонгох, дадлага ажлыг чанартай гүйцэтгэхэд арга зүйн удирдамжаар хангана.

5.6. Сургалтын төлбөрийн тодорхой хэсгийг сургалтын баазыг хөгжүүлэхэд зарцуулах бөгөөд хэрэгжилтийн талаар гэрээ дүгнэхэд захиалагчид танилцуулна.

5.7. Сургалтыг явуулсан талаарх тайланг суралцагчийн өргөдөлд хавсаргасан баримт бичгийг аудитор, менежерийн эрх олгох шалгалтад хамруулах хүсэлтийн хамт сургалт дууссанаас хойш ажлын З хоногт багтаан захиалагчид ирүүлнэ.

5.8. Сургалтын хөтөлбөр болон шалгалтын сорилын агуулгыг баяжуулах, сайжруулах талаар захиалагчид хүсэлт гаргах, санал боловсруулж танилцуулах байдлаар хамтран ажиллана.

5.9. Сургагч багш нарыг чадавхжуулах, практик мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх асуудлаар захиалагчтай хамтран ажиллана.

5.10. Шалгалт авах анги танхим болон тоног төхөөрөмжөөр хангах бөгөөд гэрээний 3.2.3 болон 3.2.4.-т заасан шалгалт зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1. Сургалтын хөтөлбөрийг зөвхөн сургалтын үйл ажиллагаанд ашиглах бөгөөд бусдад дамжуулахыг хориглоно.

6.2. Сургалтын байгууллага сургалтын нарийвчилсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тохиолдолд захиалагчид тухай бүр албан ёсоор мэдэгдэж, зөвшилцөнө.

6.3. Сургалт явуулах гэрээний хугацаа дууссан тохиолдолд сургалт явуулахгүй ба тус хугацаанд сургалтад хамрагдсан суралцагчдыг аудитор, менежерийн эрх олгох шалгалтад хамруулахгүй.

6.4. Сургалтын байгууллагын буруутай үйл ажиллагаанаас үүдэж суралцагчид учирсан аливаа хохирлыг захиалагч тал хариуцахгүй.

6.5. Төгсөгчийн гэрчилгээ, тэмдэг, үнэмлэх зэргийг хэвлүүлэхтэй холбоотой санхүүжилтийг шийдвэрлээгүй буюу хугацаа хоцроосонтой холбоотой хохирлыг сургалтын байгууллага бүрэн барагдуулна.

Долоо. Гэрээ цуцлах

7.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний талаар маргаан гарах, гэрээний хугацааг сунгах болон цуцлах асуудлыг хоёр тал бичгээр санал солилцох замаар шийдвэрлэнэ.

7.2. Аль нэг тал энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа зөрчсөн тохиолдолд гэрээг нэг талын санаачилгаар хугацаанаас өмнө цуцалж болох бөгөөд энэ тухай нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

7.3. Сургалт явуулах гэрээг зөрчсөн сургалтын байгууллагын гэрээг хүчингүй болгож, дараагийн нэг жилийн хугацаанд тус сургалтын байгууллагатай гэрээ байгуулахгүй.

7.4. Гэрээнд заасан хугацаа дуусмагц гэрээг хүчингүй болсонд тооцно.

Найм. Бусад

8.1. Гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

8.2. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.3. Гэрээг монгол хэлээр ... эх хувь үйлдэж, талууд нэг хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

Сургалтын байгууллагыг төлөөлж:

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

---оОо---



Эрчим хүчиний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийн сургалт явуулах өргөдөл

ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг,
Их сургуулийн гудамж 2а

УХАД315 9128808

Утас: 11-320126, 11-313203

Вэб хуудас: <http://www.erc.mn>

Цахим шуудан: info@erc.mn

Манай байгууллага Засгийн газрын 2016 оны 295 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Эрчим хүчиний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журмын 3.1-д заасан шаардлагыг хангаж, эрчим хүч хэмнэлтийн мэргэжилтэн бэлтгэх, мэргшүүлэх сургалт явуулах хүснэлтэй тул өргөдөл гаргаж байна.

Явуулах сургалтын чиглэл

Эрчим хүчиний аудитор- үйлдвэрлэл болон үйлчилгээ /ЭХА-YY/

Эрчим хүчиний аудитор- барилга /ЭХА-Б/

Эрчим хүч хэмнэлтийн менежер /ЭХХМ/

Байгууллагын мэдээлэл

Байгууллагын нэр	
Байгууллагын улсын бүртгэлийн дугаар	
Байгууллагын үндсэн мэдээлэл	<p>Хаяг Утас Факс И-мэйл Веб хувьдас</p>
Байгууллагын удирдлага	<p>Нэр Холбоо барих мэдээлэл</p>
Үйл ажиллагааны үндсэн чиглэл /ТББ г.м./	
Нийт ажиллагсдын тоо	

Санал болгож буй нөхцлүүд

	Тайлбар	2016	2017	2018
Сургалтын хэлбэр	тanhimyн, tanhim, дадлага хосолсон эсхүл онлайн г.м.			
Элсэгчдийн тоо /жилээр/				
Сургалтын агууллын багтаамж /кредит цаг, ЭХХМ-оос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу/	ж. ЭХХМ, ЭХА-YY			
Багшиах бүрэлдэхүүн /сургагч багшийн төвч мэдээллийг загварын дагуу жагсааж өргөдөл хавсаргах/	Хичээл заах багшийн тоо	туүнээс Доктор	туүнээс Зөвлөх	туүнээс Мэргэшсэн
	Сургалтын анги, танхимын тоо			туүнээс Магистр
Сургалтын орчин болон бааз /туршилтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалтыг загварын дагуу гаргаж хавсаргах/	Дадлаын газар/ лабораторийн нэр Сургалтад ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо Сургалт, мэдээллийн платформын нэр			

Хэвлээд баталгаажуулах хэсэг

Холбогдох журмын 3.2-д заасны дагуу өргөдөл хавсаргах баримт бичиг:

- Байгууллагын улсын бүртгэлийн хуулбар /нотариатаар баталгаажуулсан/
- Сургагч багшийн анкет болон тэдний мэргэжлийн чадавхийг илтгэх
баримт бичгийн хуулбар
- Сургалтад хамруулах суралцагчдын тоо, сургалтын төлөвлөгөө
- Сургалтын дадлага хийх газрын танилцуулга /зурагтай/
- Сургалтын хөтөлбөрийн хүрээнд сургалт явуулах мэргшүүлийн чиглэлийг
тодорхойлон танилцуулга

Нэмэлтээр

- Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар /эзэмшдэг
бол нотариатаар баталгаажуулсан/
- Сургагч багшийн төвч мэдээлэл /загварын дагуу/
- Сургалтад ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт /загварын
дагуу/

Өргөдөл гаргасан
/албан тушаалтны нэр, албан
тушаал/

20 ... оны ...
дугаар сарын
... -ны өдөр

/гарын үсэг, дардас/



Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийн сургалтад бүртгүүлэх өргөдөл

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
14201 Улаанбаатар хот.
Сүхбаатар дүүрэг.
Их сургуулийн гудамж 2а

Утас: 11-320126, 11-313203
Вэв хуудас: <http://www.erc.mn/>
Цахим шуудан: info@erc.mn

Цээж зураг
3.5*4.5

Миний бие Засгийн газрын 2016 оны 295 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчинэүй болгох журмын 4.1-д заасан шаардлагыг хангаж, эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх, мэргэшүүлэх сургалтад хамрагдах хүсэлтэй тул өргөдөл гаргаж байна.

Бүртгүүлэх сургалт	Сургалтын байгууллага	Сургалт эхлэх огноо			
Эрчим хүчний аудитор- үйлдвэрлэл болон үйлчилгээ					
Эрчим хүчний аудитор- барилга					
Эрчим хүч хэмнэлтийн менежер					
Хувийн мэдээлэл					
Эцэг/эх-ийн нэр	Нэр	Хүйс Зар Эм	Регистрийн дугаар	Төрсөн огноо	И-мэйл
Оршин суугаа хаяг	Хот/ аймаг	Хороо, гудамж	Гэрийн утас	Гар утас	
Ажлын туршилаа					
Байгууллага /сүүлийн 3 ажил олгогч/	Албан тушаал	Байгууллагын холбоо барих мэдээлэл /утас, вэбсайт,.../		Ажилласан хугацаа	
1 /Одоо ажиллаж байгаа эсхүл хамгийн удаан ажилласан/			Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	
2					
3					
Нийт ажилласан жил			...	ЖИЛ	
Боловсрол, мэргэшил					
Их, дээд сургууль	Нэр/ байршил жишээ: Уральский федеральный университет, Орос	Эзэмшсэн мэргэжил	Боловсролын зэрэг	Төгссөн он	
Коллеж, мэргэжлийн сургууль					
Бүрэн дунд боловсрол					
Мэргэшүүлэх сургалтууд /сертификаттай, 3 ба түүнээс дээш хоногийн/					
Хийж гүйцэтгэсэн ажил/ бүтээл /өргөдөл хавсаргаж болно./					
Ажил/ бүтээлийн нэр	Товч агуулга		Гүйцэтгэсэн огноо		
Мэдлэг, ур чадвар					
Гадаад хэл	мэргэжлийн түвшинд жишээ: орос	хэрэглээний түвшинд	анхан шат		
Программ хангамж	жишээ: AutoCAD	жишээ: MS Office-Word, Excel			
Бусад ур чадвар					
Хэвлээд гарараа бөглөх хэсэг					
Өргөдөл гаргагч-ын миний бие энэхүү өргөдөлд мэдээллээ үнэн зөв, бүрэн өгсөн болно.		Өргөдөл гаргасан			
Холбогдох журмын 4.1-д заасны дагуу өргөдөлд хавсаргах баримт бичиг:		/гарын үсэг/			
1. Иргэний үнэмлэхийн хуулбар 2. Нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар 3. Цээж зураг 2 хувь /3.5x4.5 хэмжээтэй/ 4. Ажил байдлын тодорхойлолт 5. Дээд боловсролын дипломын хуулбар 6. Мэргэжил дээшшуулсан талаарх үнэмлэх, гэрчилгээний хуулбар 7. ЭХЗХ-осс олгосон сургуулийн гагццийн гэрчилгээний хуулбар		20 ... оны ... дугаар сарын ... -ны өдөр			